



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 1/08

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2019 оны 02 дугаар сарын 25-наас 03 дугаар сарын 03-ны хооронд Ерөнхийлөгчийн ивээл дор зохиогдох “Үндэсний цом-2019” футзалын тэмцээнд оролцох аймгийн өсвөрийн шигшээ багийн тамирчдын бэлтгэлийг сайтар ханган оролцсугай.

2.Зардалд шаардагдах 1 000 000 төгрөг /нэг сая/ -ийг “Спортын аварга” хөтөлбөрийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ДҮГЭРЖАВ